



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР
ДҮНТЭЙ БОЛОВЧ, ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: **ӨВА-2024/18-14-ШТА-ГА**

Өвөрхангай аймаг



Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын
Дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал

Утас:70323253, Цахим хаяг:BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас:70323833, Цахим хаяг:gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Шийлэгмаа

Утас:70323833, Цахим хаяг:shiilegmaas@audit.gov.mn

Аудитор: Б.Баяртогтох

Утас:70323108, Цахим

хаяг:bayartogtokhb@audit.gov.mn

Аудитор: П.Норпил

Утас: 70323833, Цахим хаяг: norpilp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг

Дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Open.audit.mn



АГУУЛГА

4

Хүснэгтийн товъёг
Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

6

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн ч хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.....

- A.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан төлөвлөсөн байна
- A.2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна
- A.3. Төсөл, арга хэмжээний 84.4 хувийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар төлөвлөсөн байна.....
- A.4.Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил гарсан байна.....
- A.5. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна

БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл сайжирч, санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан санхүүжүүлсэн байна.....

- Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн байна
- Б.2.Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна.....
- Б.3. Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна.....
- Б.4.Захиалагч, улсын комисс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн байна.....
- Б.5. Хүлээн авсан засварын ажил, нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна
- Б.6. Төсөл арга, хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна
- Б.7.Төсөл арга, хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна.....

БҮЛЭГ 3. Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна. 15

- В.1. Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж байна ..
- В.2. Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.....
- В.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь 84.4 хувьтай байна.....

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд: 22

ЗӨВЛӨМЖ: 22



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБООС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБ	Барилга, хот байгуулалт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БУ	Барилга угсралт
БШУ	Боловсрол шинжлэх ухаан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТӨӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

**Хүснэгтийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгагдсан байдал	7
Хүснэгт 2	ТАХ-ний хяналтын болон батлагдсан төсөвт өртгийг харьцуулалт /мян.төг/	8
Хүснэгт 3	Аймгийн ИТХ-аар баталсан ТАХ-ний хэрэгжих хугацаа, төсөвт өртөг /мян.төг/	9
Хүснэгт 4	Аймгийн ХААГ-аас ирүүлээгүй тендерийн жагсаалт, төсөвт өртөг /мян.төг/	11
Хүснэгт 5	Капиталжуулалт хийж бүртгээсэн төсөл, арга хэмжээ	15

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Бат-өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны засвар	12
Зураг 2	Хайрхандулаан сумын соёлын төвийн ариун цэврийн өрөөний засвар	12
Зураг 3	Тэмүүлэл эрдэм сургуулийн заалны засвар	13
Зураг 4	Аэрологийн өртөөний засвар	13
Зураг 5	Шуурхай удирдлагын нэгжийн барилга	13

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Хөрөнгө оруулалтын төрөл	6

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
---	---------	-----------------



Аудитын нэр	Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Аудитын код	ӨВА-2024/18-14-ШТА-ГА
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын дэд төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.</p>
Аудитын зорилт	<p>Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p>
Аудитын хамарсан хүрээ	<ul style="list-style-type: none"> ➢ Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж, ХАА хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх, ➢ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, ➢ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, <p>Аудитаар Өвөрхангай аймагт 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХБТХОХ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг хийлээ.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитыг гүйцэтгэхдээ аудитын стандарт АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго зорилт асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.</p>

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, ахлах аудитор С.Шийлэгмаа, аудитор Б.Баяртогтох, П.Норпил нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.03.25-2024.06.01-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын
тайлангийн бүтэц**

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт зөвлөмж, холбогдох байгууллагын санал хэсгээс бүрдсэн.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БОЛОВЧ, ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.**

Аудитын дүн: 2 зөвлөмж, нийт 1,714.5 сая төгрөгийн 2 хугацаатай албан шаардлага өгч ажиллав.

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн ч хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна

А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан төлөвлөсөн байна


Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/02 тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2020 оны 03/03 тогтоолоор тус тус баталжээ.

“Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх барилга, байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалт”-д 833.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээнд 660.0 сая төгрөгийг баталсан байна.

Мөн 2023 онд хэрэгжүүлэх их засварын 1,395.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг 1,000.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр жагсаалтаар баталсан. Уг жагсаалтын 4-т заасан Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн сантехникийн засварыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр болсон тул уг зардлыг аймгийн ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 19/05 дугаар тогтоолоор 8 төсөл арга хэмжээний зардалд хуваарилжээ.

Нийт төсөл, арга хэмжээний 35.9 хувийг боловсрол, 15.3 хувийг эрүүл мэнд, 7.2 хувийг соёл, 24.1 хувийг нутгийн өөрөө удирдах байгууллага, 17.4 хувийг бусад салбарт хөрөнгө оруулахаар төлөвлөжээ. Үүнийг графикаар харуулбал:

Дүрслэл 1 Хөрөнгө оруулалтын төрөл



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих нийт төсөл, арга хэмжээг Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан төлөвлөжээ.

Хүснэгт 1 Үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгагдсан байдал

№	БББ-ын нэр	Ерөнхий байдлаар уялдсан ТАХ-ны тоо	Шууд уялдсан ТАХ-ний тоо	Уялдаагүй ТАХ-ний тоо
1	Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	9	-	-
2	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт	4	10	-

Аймгийн дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх зорилт, үйл ажиллагаа тодорхой болсноор урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бодитой нөхцөл байдал бий болдог. Дунд хугацааны зорилтууд хэрэгжсэнээр иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй чанартай хүргэх, эрүүл аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлж, байгаль орчныг хамгаалан, орон нутгийг хөгжүүлэх боломж бүрдэж байна.

А.2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг баталсан Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 160 дугаар тогтоолыг хүчингүйд тооцож, 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор шинэчлэн баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт гэж улс болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэж заасантай нийцээгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус, бага өртөг бүхий урсгал зардалд тусгаж болох 4 төсөл арга хэмжээнд 22.3 сая төгрөг төлөвлөж баталсан байна. Үүнд:

- Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлгийн засварын зардал 4.5 сая төгрөг
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын цахим сургалт мэдээллийн цэгийн тохижилт 9.5 сая төгрөг
- Баян-Өндөр сумын Цаг уурын өртөөний барилгын газардуулга 4.5 сая төгрөг
- Шүүхийн шинжилгээний хэлтсийн байрны хамгаалалт болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах зардал 3.8 сая төгрөг

Өвөрхангай аймагт 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 13 төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй, магадлалаар баталгаажуулсан зураг төсөл болон төсөвт үндэслэхгүйгээр төсөвт тусгаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь өртгийн зөрүү үүсгэж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж, төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна.

Төсөл, арга хэмжээний хяналтын болон батлагдсан төсөвт өртгийг харьцуулж харуулбал:

Хүснэгт 2 ТАХ-ний хяналтын болон батлагдсан төсөвт өртгийг харьцуулалт /мян.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хяналтын төсөв	Батлагдсан төсөвт өртөг
1	Аймгийн Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төв	269,978.95	323,200.00
2	Сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн албан хэрэгцээний байр	438,245.30	400,000.00
3	Арвайхээр сумын ЕБ-ын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засвар	80,014.16	183,000.00
4	Бүрд сумын ЕБС-ийн дээврийн засвар	85,650.10	90,000.00
5	Бат-өлзий сумын ЕБС-ийн дотуур байрны засвар	83,770.59	70,000.00
6	Өлзийт сумын ЕБС-ийн дотуур байрны засвар	42,566.23	40,000.00
7	Арвайхээр сумын 9-р цэцэрлэгийн бохирын шугамыг нэгдсэн шугамд холбох	39,402.98	44,000.00
8	Баян-Өндөр сумын ЕБС-ийн засвар	87,240.52	80,000.00
9	Уянга сумын Соёлын төвийн их засвар	106,393.73	134,000.00
10	Хайрхандулаан сумын Соёлын төвийн ариун цэврийн өрөөний завсар, инженерийн шугам сүлжээний засвар	22,782.13	24,000.00
11	БОЭТ-ийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар, Бүрд сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар	186,025.51	200,000.00
12	Баруунбаян-Улаан сумын эмнэлгийн засвар	105,044.21	100,000.00
13	Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн Арвайхээр аэрлогийн өртөөний газгенераторын байрны засвар	59,739.87	57,300.00
Нийт дүн		1,606,854.27	1,745,500.00

Аудитын явцад аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд тавигдах шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан, холбогдох хууль, журмын хүрээнд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг сум, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төсөвлөсөн эсэх нь тодорхойгүй,
- Төсөвт байгууллагуудаас ирүүлсэн төсвийн санал, баримт ирүүлээгүй, төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгээр хангаагүй,
- Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн саналыг цахим системд оруулаагүй,
- Төслийн саналыг шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэн үнэлсэн эсэх тодорхойгүй,
- Барилга байгууламжийг магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй төлөвлөсөн,
- Их засварын зардлын холбогдох баримт бичигт үндэслээгүй, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэх нь тодорхойгүй,

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бага өртөг бүхий, урсгал зардалд тусгаж болох зардлууд санхүүжүүлэхгүйгээр тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагатай, тооцоо судалгаатай ажлуудыг төлөвлөх, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасныг баримтлан ажиллах шаардлагатай.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтан гаргасан тул ХБТХОХ-ийн дарга, мэргэжилтэнд зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

А.3. Төсөл, арга хэмжээний 84.4 хувийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар төлөвлөсөн байна

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа, санхүүжилтыг дараах байдлаар баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 Аймгийн ИТХ-аар баталсан ТАХ-ний хэрэгжих хугацаа, төсөвт өртөг /мян.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Аймгийн Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төв	2023	2023	323,200.00	150,000.00
2	Бүрд сумын онцгой комиссын автомашин худалдан авах	2023	2023	60,000.00	60,000.00
3	Хархорин сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны камержуулалт	2023	2023	50,000.00	50,000.00
4	Сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн албан хэрэгцээний байр	2023	2023	400,000.00	400,000.00
5	Арвайхээр сумын ЕБ-ын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засвар	2023	2023	183,000.00	80,000.00
6	Бүрд сумын ЕБС-ийн дээврийн засвар	2023	2023	90,000.00	90,000.00
7	Бат-өлзий сумын ЕБС-ийн дотуур байрны засвар	2023	2023	70,000.00	70,000.00
8	Төгрөг сумын цэцэрлэгийн барилгын засвар	2023	2023	50,000.00	50,000.00
9	Өлзийт сумын ЕБС-ийн дотуур байрны засвар	2023	2023	40,000.00	40,000.00
10	Арвайхээр сумын 9-р цэцэрлэгийн бохирын шугамыг нэгдсэн шугамд холбох	2023	2023	44,000.00	40,000.00
11	Баян-Өндөр сумын ЕБС-ийн засвар	2023	2023	80,000.00	80,000.00
12	Уянга сумын Соёлын төвийн их засвар	2023	2023	134,000.00	100,000.00
13	Хайрхандулаан сумын Соёлын төвийн ариун цэврийн өрөөний завсар, инженерийн шугам сүлжээний засвар	2023	2023	24,000.00	20,000.00
14	БОЭТ-ийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар, Бүрд сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар	2023	2023	200,000.00	200,000.00
15	Баруунбаян-Улаан сумын эмнэлгийн засвар	2023	2023	100,000.00	100,000.00
16	Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлгийн засвар	2023	2023	4,480.00	4,480.00
17	Зүүнбаян-Улаан сумын ЕБС-ийн дотор засвар	2023	2023	18,100.00	18,100.00
18	Арвайхээр сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн дотор засвар	2023	2023	12,400.00	12,400.00
19	Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн Арвайхээр аэрлогийн өртөөний газгенераторын байрны засвар	2023	2023	57,300.00	57,300.00
20	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын цахим сургалт мэдээллийн цэгийн тохижилт	2023	2023	9,500.00	9,500.00
21	Арвайхээр сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байрны душ, ариун цэврийн өрөөний засвар	2023	2023	19,920.00	19,920.00
22	Баян-Өндөр сумын Цаг уурын өртөөний барилгын газардуулга	2023	2023	4,500.00	4,500.00
23	Шүүхийн шинжилгээний хэлтсийн байрны хамгаалалт болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах зардал	2023	2023	3,800.00	3,800.00
Нийт дүн				1,978,200.00	1,660,000.00

Дээрх төсөл, арга хэмжээнээс 21 төсөл, арга хэмжээ буюу 84.4 хувийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож ажиллажээ.

2023 онд хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээг дурдвал:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар
- Сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн албан хэрэгцээний байр /Есөнзүйл сумын Төрийн албан хаагчийн байр/

Аймгийн ИТХ-ын 2022 оны 15/06 дугаар тогтоолын 2, 5 дугаар хавсралтад баталсан төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа, төсвийг зөрүүтэй тусгасан 2 төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал:

- Аймгийн Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төвийн хэрэгжих хугацаа 2023-2024 , тайлант онд 150.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба дараа онд санхүүжих 173.2 сая төгрөгийг 2024 оны төсөвт тусгаагүй.
- Арвайхээр сумын Ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засвар 2023 онд 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, 2024 оны төсөвт 103.0 сая төгрөгийг тусгаагүй.

А.4.Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил гарсан байна

Аймгийн 2023 оны төсөв батлах тухай ИТХ-ын 2022 оны 15/06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 11 дэх заалтад “Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар” хийх төсөл арга, хэмжээний зардал 200.0 сая төгрөгөөр тусгагдсан.

Тус зардлыг аймгийн Засаг даргын 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А/544 дугаар захирамжаар БОЭТ-ийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар болон Бүрд сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээврийн засварт зарцуулахаар хуваарилжээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/481 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь “Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар” хийх төсөл, арга хэмжээний тендерийн баримт, бичгийг дээрх зардал хуваарилах хугацаанаас өмнө буюу 2023 оны 7 дугаар сарын 24-ны өдөр боловсруулахдаа дараах алдаа, зөрчлийг гаргасан байна.

- Тус зардлыг хуваарилах шийдвэр гараагүй байхад урьдчилан төсөвт өртгийг хуваан багц болгон зарлахаар тусгасан.
- Багцийн нийт төсөв 186.0 сая төгрөг байхад нийт төсөвт өртгийг 200.0 сая төгрөгөөр боловсруулсан.

Есөнзүйл, Гучин-Ус, Төгрөг сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн албан хэрэгцээний байрыг барих төсөл, арга хэмжээний тендерийн баримт, бичгийг боловсруулахдаа өгөгдлийн хүснэгтийг “Багцгүй”-ээр боловсруулсан байна.

А.5. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна

Өвөрхангай аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих нийт 1,905.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулснаас төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтаар 4, харьцуулалтын аргаар 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/259 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь 183.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Арвайхээр сумын Ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засварын ажлын тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, худалдан авалтын үйл ажиллагааны журмыг сонгохдоо тухайн ажлын нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй байна.

Тендерийн үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийн баримттай танилцан, үнэлгээ хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл зэргийг хурлын тэмдэглэлээр баримтжуулсан боловч зарим тендерийн баримт бичигт хянан үзсэн маягтыг бөглөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар / төсөвт өртөг 200 сая төгрөг/
- Төгрөг сумын цэцэрлэгийн барилгын засвар
- Бүрд сумын онцгой комиссын автомашин худалдан авах тендер
- Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн Арвайхээр аэрлогийн өртөөний газгенераторын байрны засвар

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь дараах 10 төсөл, арга хэмжээний тендерт оролцогчдын ирүүлсэн цахим тендерийн материалыг ирүүлээгүй, худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан эсэхэд үнэлгээ өгөх боломж олгоогүй, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заасан шалгагдагч этгээдийн үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Хүснэгт 4 Аймгийн ХААГ-аас ирүүлээгүй тендерийн жагсаалт, төсөвт өртөг /мян.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Үнэлгээний хороо байгуулсан захирамж		Тендерийн
		Нийт	Огноо	Дугаар	ТШ-ын дугаар
1	Аймгийн Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төв	323,200.00	2023.01.10	А/09	ӨВАОНӨГ/202312001
2	Бүрд сумын онцгой комиссын автомашин худалдан авах	60,000.00	2023.01.10	А/10	ӨВАОНӨГ/202312002
3	Хархорин сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны камержуулалт	50,000.00	2023.02.09	А/61	ӨВАОНӨГ/202312003
4	Сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн албан хэрэгцээний байр	400,000.00	2023.04.21	А/258	ӨВАОНӨГ/202312004
5	Бүрд сумын ЕБС-ийн дээврийн засвар	90,000.00	2023.01.10	А/137	ӨВАОНӨГ/202312024
6	Төгрөг сумын цэцэрлэгийн барилгын засвар	50,000.00	2023.04.21	А/263	ӨВАОНӨГ/202312027
7	Өлзийт сумын ЕБС-ийн дотуур байрны засвар	40,000.00	2023.03.23	А/157	ӨВАОНӨГ/202312028
8	Арвайхээр сумын 9-р цэцэрлэгийн бохирын шугамыг нэгдсэн шугамд холбох	44,000.00	2023.04.13	А/226	ӨВАОНӨГ/202312029
9	БОЭТ-ийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар	200,000.00	2023.07.24	А/481	ӨВАОНӨГ/202312033
10	Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн Арвайхээр аэрлогийн өртөөний газгенераторын байрны засвар	57,300.00	2023.06.13	А/387	ӨВАОНӨГ/202306056
		1,314,500.0	-	-	-

БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл сайжирч, санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан санхүүжүүлсэн байна.

Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн байна

Өвөрхангай аймагт орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтаар их засварын 19 төсөл, арга хэмжээг 1,395.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн тогтоолын 5 дугаар хавсралтад тусгагдсан Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн сантехникийн засварыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр болжээ. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 130.0 сая төгрөгийг шинээр хэрэгжүүлэх 8 засварын ажилд хувааж хуваарилсан байна.

Аудитад хамруулан авч үзсэн дараах төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгч нь их засварыг зураг, төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээний жагсаалтын дагуу хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засвар
Зураг 1 Сургуулийн дотуур байрны засвар




- Хайрхандулаан сумын соёлын төвийн ариун цэврийн өрөөний засвар, инженерийн шугам сүлжээний засвар

Зураг 2 Соёлын төвийн ариун цэврийн өрөөний засвар



- Тэмүүлэл эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засвар

Зураг 3 Тэмүүлэл эрдэм сургуулийн заалны засвар



- Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн Арвайхээр аэрологийн өртөөний газгенераторын байрны засвар

Зураг 4 Аэрологийн өртөөний засвар



- Аймгийн Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төв

Зураг 5 Шуурхай удирдлагын нэгжийн барилга



Аймгийн Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Дүүрэн цацрах ХХК-тай шууд гэрээ байгуулан ажилласан байна. Гэрээний нийт дүнг 150.0 сая төгрөгөөр байгуулсан бөгөөд анх тендер сонгон шалгаруулалтыг 323.2 сая төгрөгөөр зарлаж байсан. Батлагдсан ажлын зураг, төсвийг 150.0 сая төгрөгт тохируулан өөрчлөлт оруулжээ. Барилга угсралтын ажилд Онцгой байдлын алба хаагчдыг туслан гүйцэтгүүлж ажилласан тухай ашиглагч байгууллагаас мэдээлсэн.

Б.2.Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 3.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Шүүхийн шинжилгээний хэлтсийн байрны хамгаалалт болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажил хийгдсэн байна. Гадна, дотор камержуулалт, хард диск зэргийг ажлын даалгаварт туссан тоо хэмжээний дагуу гүйцэтгэсэн байна. Шинжээч эмчийн өрөөнд стандартад нийцсэн дуу, дүрс бичих зориулалттай камерыг суурилуулжээ.

Бүрд сумын онцгой комисст автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр Уаз Мега ХХК шалгаран 58.9 сая төгрөгөөр Toyota Hilux маркийн суудлын автомашин нийлүүлсэн байна. Техникийн тодорхойлолтод тусгасан шаардлагад нийцсэн автомашиныг гэрээний дагуу 2023 оны 02 дугаар сарын 10-нд хүлээлгэн өгсөн байна.

Б.3. Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06 дугаартай, 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 19/05 дугаартай “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжиж дуусах хугацааг тухайн ондоо багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Барилгын засварын ажлыг хэрэгжүүлэх хугацааг ажил гүйцэтгэх гэрээнд зааснаар тухайн онд бүрэн хэрэгжиж дуусахаар заасан байна.

БОЭТ-ийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засварын ажил нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж дуусаагүй байна. Барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдөр байгуулжээ. Бохир усны шугамын ажлыг гүйцэтгэхэд хүйтний улиралтай давхцаж байгаа нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжих боломжгүй болгосон байна. Ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 05 дугаар сарын 20 хүртэл сунгасан бөгөөд сунгалтын хугацаанд багтаан улсын комисс хүлээлгэн өгсөн байна.

Б.4.Захиалагч, улсын комисс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн байна

Их засварын 15 төсөл, арга хэмжээнд хийгдэх хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хэрэгжүүлж ажилласан байна.

Тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд хийгдэх хяналтыг ашиглагч байгууллага нь хэрэгжүүлсэн байна. Тоног төхөөрөмжийг хүлээлцэх явцад техникийн тодорхойлолтын дагуу бүрэн хэрэгжүүлсэн эсэхэд хяналтыг хийжээ.

Их засварын ажлыг хүлээн авахдаа Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4 дүгээр хавсралтад заасны дагуу комиссын гишүүдийн өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн хүлээн авсан байна. Хүлээн авах комиссын гишүүдийн саналын хуудаст хүлээн авахаас татгалзсан арга хэмжээ байхгүй.

Б.5. Хүлээн авсан засварын ажил, нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн а/62 тоот захирамжийн 1 болон 2 дугаар хавсралтад заасны дагуу 12 төсөл, арга хэмжээний 1,032.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна. Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн 3.8 сая төгрөгийг бүртгэлдээ бүрэн тусгасан байна. Захирамжийн 3 дугаар хавсралтад 2 төсөл, арга хэмжээний 343.7 сая төгрөгөөр дуусаагүй барилгад бүртгэсэн байна.

Б.6. Төсөл арга, хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна

Өвөрхангай аймгийн орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1.660,0 сая төгрөгийн 23 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 1,604.1 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ нь санхүүжилтээ бүрэн авчээ. Харин хугацаандаа хэрэгжиж дуусаагүй Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засварын ажлын санхүүжилт 181.1 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Мөн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны душ, ариун цэврийн өрөөний засварын зардал 19.9 сая төгрөгийг ажлын санхүүжилтийн эх үүсвэр нь өөрчлөгдөж дээрх төсөл, арга хэмжээний зардлыг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Б.7.Төсөл арга, хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна

Тайлант онд хэрэгжсэн ажлын гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтнуудаар батлуулж, гүйцэтгэлийг зураг, актаар баталгаажуулан нэхэмжлэлийг үндэслэн гүйцэтгэлтэй нь уялдуулан санхүүжилтийг олгосон байна.

БҮЛЭГ 3. Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.**В.1. Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж байна**

Их засварын 9 ажлын 817.3 сая төгрөгийн хөрөнгийг капиталжуулан өмчлөлд бүрэн шилжүүлж зориулалтын дагуу ашиглаж байна.

Хүснэгт 5 Капиталжуулалт хийж бүртгэсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг, ашиглагч байгууллага
1	Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын нэгжийн хяналтын төв	150.0 сая төгрөг, Онцгой байдлын газар
2	Гучин-Ус сумын төрийн албан хаагчийн байр	146.0 сая төгрөг, Гучин-Ус ЗДТГ
3	Төгрөг сумын төрийн албан хаагчийн байр	146.0 сая төгрөг, Төгрөг ЗДТГ
4	Ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засвар	79.4 сая төгрөг, Тэмүүлэл эрдэм сургууль
5	Бүрд сумын Ерөнхий боловсролын сургуулийн дээврийн их засвар	80.0 сая төгрөг, Бүрд ЕБСургууль
6	Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны их засвар	70.0 сая төгрөг, Бат-Өлзий ЕБСургууль
7	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Арвайхээр аэрологийн өртөөний газгенераторын байрны засвар	56.7 сая төгрөг, Ус цаг, уур орчны шинжилгээний газар
8	Төгрөг сумын цэцэрлэгийн барилгын засвар /дээврийн фасад/	49.7 сая төгрөг, Төгрөг сумын Цэцэрлэг
9	Арвайхээр сумын 9 дүгээр цэцэрлэгийн бохирын шугамыг нэгдсэн шугамд холбох их засвар	39.5 сая төгрөг, Арвайхээр сумын 9-р цэцэрлэг

В.2. Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна

Барилга байгууламжийн үндсэн хийцлэл, ашиглалтад сайжруулалт хийгдсэн тул бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. Шинээр нийлүүлсэн тоног төхөөрөмж нь ашиглагчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж ашиглалт сайтай байна.

В.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь 84.4 хувьтай байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төсөвт байгууллагуудын санал, албан бичиг зэрэг баримтыг ирүүлээгүй тул сум, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөөгүй гэж дүгнэж байна.

Өвөрхангай аймгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 23 төсөл, арга хэмжээнээс 84.4 хувь нь үр дүнтэй хэрэгжиж, 15.6 хувь буюу 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайлан баталгаажуулах тушаал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/17

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг”-ийн 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (ӨВА-2024/18-14-ШТА-ГА)-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Аймгийн Засаг дарга (И.Доржсүрэн)-д зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг аудитын менежер (Д.Гансүх), гүйцэтгэл-нийцлийн багийн ахлах аудитор (С.Шийлэгмаа) нарт үүрэг болгосугай.

4. Тайланг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Шийлэгмаа)-д үүрэг болгосугай.




О.БАТЖАРГАЛ

015010048

D:\Audiitiin gazar\Baiguullagiiin dotood barimt\Tushaal

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 06 дүгээр сарын 05-ний А/17 тоот тушаалын хавсралт



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	Есөнзүйл, Гучин-Ус, Төгрөг сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн албан хэрэгцээний байрыг барих 400.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний тендерийн баримт, бичгийг боловсруулахдаа өгөгдлийн хүснэгтийг "Багцгүй"-ээр боловсруулж тендер зарласан.	360/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	400.0
2	Их засварын ажлын 1,314.5 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний тендерт оролцогчдын ирүүлсэн цахим тендерийн материалыг ирүүлээгүй, худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан эсэхэд үнэлгээ өгөх боломж олгоогүй.	361/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	1,314.5
3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бага өртөг бүхий, урсгал зардалд тусгаж болох зардлууд санхүүжүүлэхгүйгээр, тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагатай, тооцоо судалгаатай ажлуудыг төсөвлөх, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасныг баримтлан ажиллах шаардлагатайг 2020, 2021, 2022 онуудад хийгдсэн аудитаар зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүйн улмаас зөрчил давтан гаргасаар байна.	361/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	
Нийт дүн			1,714.5

Холбогдох байгууллагын санал:



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2376, 7032 2325,
Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2024.06.05 № 1/303

танай _____-ны № _____-г

Санал хүргүүлэх тухай

“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлантай танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмжийн 3 дугаарт дурдагдсан Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам”-д заасны дагуу тухайн жилд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээний мэдээллийг цахим системд иж бүрэн байршуулж ажиллана гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл бүрэн цахимжсан.

Сангийн яамнаас хөгжүүлж байгаа pimis.publicinvestment.gov.mn цахим системд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл цахимжуулахаар бэлтгэл ажлыг хангуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төсөв баталсан тогтоолыг хүргүүлж системд байршуулсан.

Одоогийн байдлаар Нийслэл бүрэн цахимжсан бөгөөд программд мэдээлэл байршуулах мэргэжилтнүүдэд сургалт хийх, гүйцэтгэл шууд компаний дансанд шилжих хөгжүүлэлтүүд Сангийн яаман дээр хийгдэж байгаа тул зөвлөмжөөс энэ заалтыг хасуулах саналтай байна.

Мөн сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлагад заасан алдаануудыг цаашид давтан гаргахгүй байх талаар хэлтсийн дарга, мэргэжилтэнд сануулга өгсөн тул албан шаардлагыг хүлээн авах боломжгүй байх тул хасуулах саналтай байна.



И.ДОРЖСҮРЭН

6224 14 0351



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2307,

Цахим шуудан: uvprocurement@ov.gov.mn,
Цахим хуудас: www.ov.hudaldan.avah.mn

2024.06.05 № 238

танай _____ -ны № _____ -г

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тус тайлангийн төсөлд оруулах саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН ХҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ИДЭРСАЙХАН



6222/0074



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Рашаант 338, 8 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62169,
Утас/факс: (976) 7032 3720,
Цахим шуудан: uvurkhangai@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.ovorkhangai.gazar.gov.mn

2024.06.05 № 250
танай 2024.06.03 -ны № 283 -Т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Танай газраас “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийсэн дүгнэлттэй танилцлаа.

2023 онд хэрэгжиж дуусаагүй 2 төслийн хувьд

1. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засварын ажил 10 сард гэрээ байгуулсан тул гадна бохирын худаг, шугамыг засварлах ажил хүйтний улирал эхэлсэн тул гүйцэтгэх боломжгүй, мөн ажлын зураг, төсөв бодит гүйцэтгэх ажилтай зөрсөн тул зургийн автор, ашиглагчтай зөвлөлдөж ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж гүйцэтгүүлсэн. Тус засварын ажилд 2024 оны 05 дугаар сарын 20-нд комисс ажиллуулж хүлээн авсан.

2. Сумдад нэн шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн хэрэгцээний байр /Есөнзүйл сумын төрийн албан хаагчийн байр/-ны барилгад 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр комисс зохион байгуулж ажиллуулсан. Комиссын гишүүдийн үүрэг даалгавар биелэгдэж дуусаагүй, хүйтний улирал эхэлсэн, мөн гадна цахилгааны түр шугам нь хулгайд алдагдсан тул дахин шугам татуулах ажлыг гүйцэтгүүлж дуусаад байна. Гүйцэтгэгч байгууллагаас үүрэг даалгаврын биелэлт хангагдсан гэсэн мэдэгдлийг ирүүлсэн тул маргааш ажлын хэсэг явуулж биелэлтийг шалгуулахаар шийдвэрлээд байна.

ДАРГА



Т.АРИУНБОЛД

622403055

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд:

- Аймгийн хөрөнгө оруулалтыг Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөж байна.
- Төсөл, арга хэмжээний саналд судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргаж ажиллаагүй байна.
- Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж төлөвлөж, баталсан байна.
- ХБТХОХ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- Захиалагч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга И.Доржсүрэнд:

1. Төсөл, арга хэмжээний саналд судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргаж батлах;
2. Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;